

“СОНГУУЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ҮЗЭЛ БОДОЛ”

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Монгол улсын Засгийн газар
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
Монголын Улс төр судлалын холбоо
“ДК-Монгол” клуб

Улаанбаатар хот
2005

АГУУЛГА

БҮЛЭГ 1. Удиртгал	1-2
1.1 Үндэслэл	1
1.2 Судалгааны зорилго	1-2
БҮЛЭГ 2. Түүвэрлэлт ба хамрагдалт	2-4
2.1 Түүвэрлэлт	2
2.2 Судалгаанд хамрагдалт	2-4
БҮЛЭГ 3. Судалгааны гол үр дүн	4-25
3.1 Сонгууль, сонгуулийн систем	4-8
3.2 Нэр дэвшигч, нам, парламентийн талаар	8-14
3.3 Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаа	14-17
3.4 Сонгуулийн санхүүжилт	17-21
3.5 Их эвслийн засгийн газрын талаарх үзэл бодол	21-25
БҮЛЭГ 4. Санал, дүгнэлт	25-26
Хавсралт: Асуулгын хуудас	27

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1 Үндэслэл

Монгол Улсын Их Хурлын даргын 2004 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 92 тоот тушаалаар Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулсан билээ.

Ажлын хэсгийн зорилго нь Монгол Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн төлөөллийн системийг боловсронгуй болгох, Сонгуулийн ерөнхий хороо, салбар хороодын үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, сонгуулийн санхүүжилтийг ил тод болгох замаар нийгмийн ардчилсан байгууллыг бэхжүүлэх явдалд оршино.

Ажлын хэсэг дээрх зорилгыг хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэлтэй байх зорилтын үүднээс дэргэдээ туслах баг байгуулсан юм. Туслах багийн үндсэн үүрэг нь сонгуулийн хуулийг шинэчлэн боловсруулахад шаардлагатай судалгааны чиглэлийг тодорхойлох, судалгааны даалгавар боловсруулан захиалах, судалгааны ажлын уялдаа холбоог хангах, үр дүнг нэгтгэн дүгнэж, эцсийн дүгнэлтийг бодлогын зөвлөмж болгон ажлын хэсэгт танилцуулах, хууль батлах явцад өмнөх судалгааны дүнг ашиглан байнгын зөвлөмжөөр хангах, түүнчлэн батлагдсан хуулийг олон нийтэд сурталчилах зэрэг болно.

Энэ зорилтыг хэрэгжүүлэн, ажлын хэсгийг бодитой тоон мэдээллээр хангахын тулд туслах баг хэд хэдэн судалгааны чиглэлийг тодорхойлсон бөгөөд үүний нэг нь сонгуулийн системийн талаарх олон нийтийн үзэл бодлыг тандах судалгаа юм.

1.2 Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь Монгол Улсын их хурлын сонгуулийн системийн давуу болон сул талыг тодруулж, цаашид анхаарах асуудлын талаар олон нийтийн үзэл

бодлыг илрүүлэн гаргахад оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

1. Сонгогчдын санал болон сонгуулийн дүн, парламент дахь төлөөлөл хоорондын холбоонд олон нийт сэтгэл хангалуун байгаа эсэхийг тодорхойлох;
2. Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаа сонгогчдын хүсэл сонирхолд нийцтэй байгаа эсэхийг тодорхойлох;
3. Сонгууль, нэр дэвшигчдийн санхүүжилтийн талаарх сонгогчдын мэдээллийн цар хүрээг тодорхойлох.

БҮЛЭГ 2. ТҮҮВЭРЛЭЛТ БА ХАМРАГДАЛТ

2.1 Түүвэрлэлт

Судалгааг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар тоон судалгааны аргыг ашиглан явууллаа. Бүсийн төлөөллийг харгалзан Улаанбаатар хот, Дорнод, Өмнөговь, Увс, Хөвсгөл аймгуудыг сонгосон бөгөөд аймаг тус бүрээс аймгийн төвийн нэг баг, хөдөөгийн сумын нэг багийг тус тус судалгаанд хамруулсан.

Судалгааны нийт түүврийн хэмжээ 1100 хүн. Түүврийн хэмжээг тогтоохдоо түүврийн алдааны хэмжээ 1.5 хувь, түүврийн ач холбогдлын түвшин 95% байхаар оруулан тооцоолов. Түүврийн нэгж нь хувь хүмүүс, өрх байлаа. Судалгаанд сонгогдсон өрх бүрээс 18-аас дээш насны нэг хүнийг энгийн санамсаргүй түүврийн аргыг ашиглан сонгож, ганцаарчилсан ярилцлагад хамруулсан. Судалгаанд мэдээлэл цуглуулах ганцаарчилсан ярилцлагын аргыг ашигласан бөгөөд ганцаарчилсан ярилцлагад урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсыг хэрэглэв.

2.2 Судалгаанд хамрагдалт

Судалгаанд Дорнод, Өмнөговь, Увс, Хөвсгөл аймаг тус бүрээс 200 хүн, Улаанбаатар хотоос 300 хүн, нийт 1100 хүнийг хамруулсан. Судалгаанд хамрагдагсдын ерөнхий шинж байдлыг хүснэгт 2.1-т үзүүлэв. Хүснэгтээс харахад судалгаанд нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн статусын ялгаатай төлөөлөл бүрээс хамрагдаж чадсан байна. Тухайлбал, нийт хүмүүсийн 35.1 хувь нь 18-29

насны, 28.3 хувь нь 30-39 насны, 22.7 хувь нь 40-49 насны, 8.8 хувь нь 50-59 насны, үлдсэн 5.1 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан байв. Судалгаанд оролцогчдын 46.3 хувь нь эрэгтэйчүүд, 53.7 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

Хүснэгт 2.1: Судалгаанд хамрагдагсдын шинж байдал, аймгаар

Сонгогдсон үзүүлэлт	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Насны бүлэг						
18-29	27.5	34.5	35.0	32.0	42.8	35.1
30-39	30.5	32.0	23.5	28.5	27.3	28.3
40-49	24.0	18.5	33.5	26.0	15.3	22.7
50-59	14.0	8.5	5.5	9.5	7.3	8.8
60+	4.0	6.5	2.5	4.0	7.3	5.1
Хүйс						
Эрэгтэй	46.5	49.5	41.0	44.5	48.7	46.3
Эмэгтэй	53.5	50.5	59.0	55.5	51.3	53.7
Гэрлэлтийн байдал						
Ганц бие	22.5	14.5	22.0	20.0	28.0	22.0
Гэрлэсэн\хамт амьдардаг	65.5	68.5	73.5	73.0	59.3	67.2
Салсан\бэлэвсэн\ тусгаарласан	12.0	17.0	4.5	7.0	12.7	10.8
Боловсролын түвшин						
Боловсролгүй\ бага боловсролтой	2.5	7.0	1.5	1.5	1.0	2.5
Бүрэн бус дунд	15.5	13.5	13.0	15.0	13.7	14.1
Бүрэн дунд	23.5	26.5	20.0	21.0	27.7	24.1
Техникийн	8.5	5.0	4.0	8.0	5.0	6.0
Тусгай дунд	27.0	12.5	18.5	18.5	9.3	16.5
Дээд	23.0	35.5	43.0	36.0	43.3	36.8
Ажил эрхлэлт						
Төрийн төсвийн байгууллага	28.0	27.0	46.0	25.5	24.7	29.7
Төрийн өмчийн ААН, байгууллага	3.5	6.5	6.5	1.0	6.3	4.9
Хувийн өмчийн ААН, байгууллага	10.0	20.5	13.0	14.0	19.0	15.6
Малчин	3.5	2.0	5.5	13.5	0.0	4.5
Оюутан	7.0	0.0	8.5	2.0	9.0	5.6
Хувиараа ажил, наймаа хийдэг	7.0	10.5	6.5	13.0	13.3	10.4
Төрийн бус байгууллага	3.5	2.5	1.5	0.0	1.0	1.6
Ажилгүй	37.5	31.0	12.5	31.0	26.7	27.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшний байдлыг авч үзвэл, тэдний гуравны нэг нь дээд боловсролтой, дөрөвний нэг нь бүрэн дунд боловсрол

эзэмшсэн, үлдсэн хэсэг нь бүрэн бус дунд, техник, тусгай дунд болон бага боловсролтой хүмүүс байна.

Судалгаанд хамрагдагсдын 27.6 хувь нь одоогийн байдлаар ямар нэгэн ажил эрхлээгүй байгаа ажилгүйчүүд, 4.5 хувь нь малчид, 5.6 хувь нь оюутнууд, 15.6 хувь нь хувийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагад, 10.4 хувь нь хувиараа ажил, наймаа эрхлэгчид, 29.7 хувь нь төрийн төсвийн байгууллагад, 4.9 хувь нь төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагад, үлдсэн 1.6 хувь нь төрийн бус байгууллагад ажиллагсад байна.


БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Өмнөх бүлгүүдэд судалгааны үндэслэл, зорилго, түүвэрлэлт болон судалгаанд хамрагдалтын талаар өгүүлсэн бол энэхүү бүлэгтээ судалгааны гол үр дүнгүүдийг танилцуулах юм.

3.1 Сонгууль, сонгуулийн систем


Монгол улс ардчилсан сонгуулийн системд шилжин, сонгуулиа явуулсаар даруй 14 жилийг ардаа орхижээ. Энэ хугацаанд УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын дөрвөн удаагийн сонгууль болсон. Сонгууль бүрийн үр дүн улс эх орон, засгийн газар, олон нийтэд сайнтай, муутай олон үр дагаврыг авчирч байсан гэдгийг хэн хүнгүй мэдэх билээ. Ер нь аливаа сонгуулийн үр дүн сонгогчдын эцсийн сонголтоос шууд хамаардаг ч эргээд сонгогчдод ямар үр нөлөөтэй байдаг талаар өгүүлсэн баримт материалууд ховор байдаг. Тэгвэл энэхүү судалгааны хүрээнд сонгуулийн үр дүн сонгогчдын амьдралд хэр зэрэг нөлөөтэй байдаг талаар судалсан бөгөөд үр дүнг Зураг 3.1-д үзүүллээ. Судалгааны дүнгээс харахад, судалгаанд оролцогчдын тавны нэг хувь сонгуулийн үр дүн тэдний амьдралд ямар нэгэн нөлөө үзүүлдэггүй гэж үзэж байхад үлдсэн хэсэг нь их, бага хэмжээгээр ямар нэгэн нөлөө мэдрэгддэг гэж хариулсан байна.

Зураг 3.1: Сонгуулийн үр дүн сонгогчдын амьдралд нөлөөлдөг эсэх



Сүүлийн үед сонгуулийн систем хоцрогдсон, түүнийг өөрчлөх шаардлага, хэрэгцээ байна, сонгуулийн системийн энэхүү байдлаас болж сонгуулийн үр дүнд сөрөг үр дагаврыг их авчирч байна гэх зэргээр хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн дунд цөөнгүй яригдах болжээ. Иймд одоогийн сонгуулийн систем өнөөгийн бодит байдалд үнэхээр нийцтэй байж чадаж байгаа эсэх буюу сонгогчдын санал болон сонгуулийн дүн, парламент дах төлөөлөлд олон нийт хэр зэрэг сэтгэл хангалуун байгаа талаарх үзэл бодлыг судалсан юм. Судалгаанд оролцогчдын 42.5 хувь өнөөгийн сонгуулийн системийг “буруу” гэж үзэж байна. Судалгаанд хамрагдсан аймаг, хот тус бүрээр авч үзвэл, Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хүмүүсийн 56.3 хувь сонгуулийн систем “буруу” гэж үзэж байхад энэ хувь бусад аймгуудад 31.5-39.0 хувь байна. Хариулт авах явцад нийт хариулагчдын гуравны нэг буюу 31.0 хувь нь өнөөгийн сонгуулийн систем, түүний зарчмын талаар тодорхой ойлголт мэдлэг байхгүй учраас “зөв” эсвэл “буруу” гэсэн үнэлгээг өгч чадахгүй гэжээ. Харин өнөөгийн сонгуулийн системийг “зөв” гэж 26.5 хувь нь л үзэж байна. Эндээс дүгнэж хэлэхэд, одоогийн сонгуулийн системийг өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Сонгуулийн системийг чухам яагаад “буруу” гэж үзэж байгааг дараагийн хэсгүүдэд зарим тоо мэдээллээр баталгаажуулах болно.

Зураг 3.2: Одоогийн сонгуулийн систем зөв эсэх



Дээрх зургаас харахад сонгуулийн систем зөв эсэхийг үнэлэх чадвар байхгүй, мэдлэг хангалтгүй байдал Улаанбаатар хотод бусад аймгуудтай харьцуулахад бага байгаа нь хөдөө орон нутгийн хүмүүсийн сонгуулийн системийн талаарх мэдлэгийн түвшин хангалтгүй байна гэж хэлж болно. Ганцаарчилсан ярилцлагын явцад ард иргэд сонгуулийн тухай хууль, өнөөгийн сонгуулийн систем, механизмын талаарх ойлголт мэдлэг муу, сонгуулийн хуулийн талаар бараг ямар ч ойлголтгүй байдаггүй тухайгаа ярьж байсан. Иймд сонгуулийн систем, сонгуулийн хуулийн талаарх олон нийтийн мэдлэгийн түвшинг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг төв, орон нутагт зохион байгуулах, ард иргэдийн улс төрийн боловсрол, сонгох, сонгогдох эрх, үүргийн ач холбогдлыг таниулан сурталчлах, иргэдийн оролцоог идэвхжүүлэх, нэмэгдүүлэх зэрэг олон үйл ажиллагааг явуулах шаардлагатай байна.

Сонгогчдын сонгуулийн үйл ажиллагаанд хандаж буй хандлагыг тодорхойлох зорилгоор сонгуулийн санал тоололтыг хэрхэн хянаж болох талаарх олон нийтийн үзэл бодлыг сонирхож үзсэн юм. Судалгааны дүнгээс үзвэл, нийт хариулт өгсөн хүмүүсийн тавны нэг нь сонгуулийн санал тоололтыг хянах үүрэг бүхий

хөндлөнгийн хяналт буюу санал тоолох явцад ажиллах нам бус төлөөллийн үйл ажиллагааг улам нэмэгдүүлэх, сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Мөн судалгаанд оролцсон арван хүн тутмын нэг нь сонгуулийн санал хураалтыг автоматжуулсан тоног төхөөрөмж, хэрэгсэл ашиглан хийвэл, санал тоололт буруу явагдах, будлиан гарах зэрэг байдлууд устаж үгүй болно гэж бодож байгаа ажээ. Зарим хариулагчдын хувьд сонгуулийн санал тоололт зөв, буруу хийгдэх нь Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаатай шууд холбоотой тул энэхүү хорооны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх, сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах замаар хяналтыг сайжруулж болно гэж үзэж байхад зарим нь санал тоололтын хяналтад намуудын ажиглагч нар шийдвэрлэх үүрэгтэйг дурьдаад, намууд өөрсдийн хяналтыг шударга, зөв хийх, сайжруулах шаардлагатай гэж үзэж байгаа аж.

Хүснэгт 3.1: Сонгуулийн санал тоололтын хяналтыг хэрхэн хийх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Намуудын хяналтыг сайжруулах	3.0	11.5	9.0	9.5	7.3	8.0
Нам бус төлөөллийн хяналтыг нэмэгдүүлэх	24.0	21.5	14.5	18.5	16.0	18.6
СЕХ-ны үйл ажиллагааг сайжруулах\шинэчлэх	5.0	5.5	4.5	12.5	8.4	7.3
Сонгуулийн хууль өөрчлөх	4.0	3.0	0.5	0.5	6.0	3.1
Автоматжуулсан төхөөрөмж ашиглах	3.0	10.5	14.5	8.5	15.0	10.7
Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шууд нэвтрүүлэх	9.0	10.0	5.0	0.5	20.0	9.9
Гадаад орнуудаас туршлага судлах	0.0	1.5	0.0	2.0	0.7	0.8
Одоогийн хяналт боломжийн гэж үзэж байна	3.5	14.0	4.0	6.5	2.3	5.7
Бусад	2.0	2.0	2.0	4.0	1.0	2.1
Мэдэхгүй	46.5	20.5	46.0	37.5	23.3	33.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Хариулагчдын хариултыг хот, хөдөөгийн сонгогчдын хувьд гэж ангилан үзвэл, хотын сонгогчид сонгуулийн санал тоололтыг автоматжуулсан тоног төхөөрөмжөөр хийх, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар шууд нэвтрүүлэг хийх замаар санал тоололтын хяналтыг хийх нь зүйтэй гэж үзэж байхад хөдөөгийн сонгогчдын хувьд нам бус төлөөллийн хяналтыг нэмэгдүүлэх, сайжруулах замаар санал тоололтын хяналтыг боловсронгуй болгож болох юм гэж үзэж байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн гуравны нэг нь сонгуулийн санал тоололтын хяналтыг хэрхэн хийх талаар ямар нэгэн бодолгүй, хэлэх зүйл байхгүй, энэ тухай бодож байгаагүй, судалгаа авах үед ямар нэг санал хэлж мэдэхгүй байв. Энэ нь нэг талаас сонгогчдын сонгууль, улс төрийн идэвх сул дорой байгааг, нөгөө талаас сонгогчдын сонгуулийн үйл ажиллагааны талаарх мэдлэг хангалтгүй байгааг харуулж байгаа хэрэг юм.

3.2 Нэр дэвшигч, нам, парламентийн талаар

Судалгааны энэхүү хэсэгт нэр дэвшигч, парламентийн талаарх олон нийтийн үзэл бодлыг харуулах үүднээс сонгууль өгөхдөө сонгогчдын эрхэмлэдэг хүчин зүйлс болон УИХ-д намууд нэр дэвшигчдийг сонгохдоо эрхэмлэдэг хүчин зүйлийн талаар асуусан ба сонгуульд нэр дэвшихийн тулд мөнгө/хандив өгч байгааг юу гэж боддог талаар ч мөн тодруулсан. Түүнчлэн парламент дэх намуудын талаар хэд хэдэн асуулт оруулсан юм.

Сонгогчдын сонгууль өгөхдөө эрхэмлэдэг хүчин зүйлийг хүснэгт 3.2-р харуулав. Хүснэгтээс харахад нийт сонгогчдын тал хувь буюу 50.5 хувь нь нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг харж сонгуульд саналаа өгдөг гэсэн бол 35.9 хувь нь нэр дэвшигч аль намынх гэдгийг харгалздаг, үлдсэн 13.6 хувь нь нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг гол болгодог гэжээ.

Хүснэгт 3.2: Сонгогчдын сонгууль өгөхдөө эрхэмлэдэг хүчин зүйлсийн талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Нэр дэвшигч аль намынх гэдгийг хардаг	34.5	35.5	25.5	46.0	37.3	35.9
Нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг хардаг	53.5	54.5	59.5	43.5	44.3	50.5
Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг гол болгодог	12.0	10.0	15.0	10.5	18.4	13.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Аймаг/хотоор ялгаатай авч үзвэл, нэр дэвшигч аль намынх гэдгийг хардаг гэсэн хувь Хөвсгөл аймагт өндөр буюу 46.0 хувь байхад энэ хариултын хувь Увс аймагт бусад аймгаас харьцангуй бага буюу 25.5 хувь байлаа. Харин нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг эрхэмлэдэг гэсэн хувь Увс аймагт бусдаас өндөр 59.5 хувь байна. Бусад 2 аймаг, Улаанбаатар хотод дээрх хандлага еранхийдөө нийт дүнтэйгээ төстэй байна. Сонгогчдын ийнхүү нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг эрхэмлэж байгаа нь нэр дэвшигчдийг орон нутаг ялангуяа, тойрогтоо ажиллах шаардлагыг сонгогчдын зүгээс тавьдагтай холбоотой байж болох юм. Энэ нь тухайн нэр дэвшигчийг намын эв нэгдэл, улс орны төлөө ажиллахаас гадна тойрогтоо амласнаа биелүүлэхийн тулд ажиллахад хүргэдэг ч байж болзошгүй.

Сонгогчдын сонгууль өгөхдөө эрхэмлэдэг хүчин зүйлийг хүснэгт 3.2-р харуулсан бол одоо намууд УИХ-д нэр дэвшигчдийг тодруулахдаа эрхэмлэдэг хүчин зүйлсийн талаар сонгогчид хэрхэн үзэж байгаа талаар сонирхож үзье. Нийт хариулагчдын 39.0 хувь нь намууд нэр дэвшигчдийг сонгохдоо ажлын туршлагыг гол болгодог гэсэн бол 26.5 хувь нь намдаа эзэлж буй байр суурийг, 16.7 хувь нь олон нийтэд танил, алдартай байдлыг, 12.4 хувь нь бэл бэнчин харгалзаж нэр дэвшигчдийг сонгодог гэсэн байна.

Нэр дэвшигчийн ажлын туршлагыг эрхэмлэж намууд нэр дэвшигчийг сонгодог гэсэн хариулт Увс аймагт хамгийн өндөр байгаа бол үүний дараа Улаанбаатар хот,

Хөвсгөл аймаг орж байна. Нэр дэвшигчийн бэл бэнчинг харгалздаг гэсэн хувь Өмнөговь, Хөвсгөл аймгууд болон Улаанбаатар хотод 15.0-16.5 хувь байгаа бол Увс аймагт хамгийн бага 4.0 хувь, Дорнод аймагт 9.5 хувь тус тус байна.


Хүснэгт 3.3: УИХ-д нэр дэвшигчдийг сонгохдоо намуудын эрхэмлэдэг хүчин зүйлсийн талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Бэл бэнчин	9.5	16.5	4.0	15.5	15.0	12.4
Олон нийгэд танил, алдартай байдал	17.0	19.5	14.0	18.0	15.7	16.7
Намдаа эзэлж буй байр суурь	34.5	13.5	34.0	26.0	25.0	26.5
Ажлын туршлага	37.5	32.0	48.0	38.5	39.0	39.0
Бусад	1.5	18.5	0.0	2.0	5.3	5.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Дээрх 2 хүснэгтээс дүгнэхэд сонгогчид болон намууд аль аль нь нэр дэвшигчийн хувийн шинж чанар буюу ажлын туршлага, нэр дэвшигчийн намын харьяалал болон намдаа эзэлж буй байр суурийг эрхэмлэдэг нь харагдлаа. Олон нийгэд танил, алдартай байдал ч гэсэн нэр дэвшигчийг сонгох нэг хүчин зүйл болдог гэж сонгогчид үзэж байгааг тэмдэглэх хэрэгтэй болов уу.

УИХ-д нэр дэвшигчийг сонгохдоо бэл бэнчин харгалздаг гэж цөөнгүй сонгогч дурьдсаныг дээр өгүүлсэн. Сонгуульд нэр дэвшихийн тулд мөнгө/хандив өгч байгааг нийт хариулагчдын 63.4 хувь нь буруу гэж хариулсан бол 14.1 хувь нь зөв, үлдсэн 22.5 хувь нь энэ талаар сайн хэлж мэдэхгүй байна гэжээ. (Зураг 3.3)

Зураг 3.3: Сонгуульд нэр дэвшихийн тулд мөнгө/хандив өгч байгаа нь зөв эсэх талаарх хариулагчдын хувийн жин



Улс төрийн намд байх ёстой шинжүүдийн талаарх хариулагчдын хувийн жинг Хүснэгт 3.4-р үзүүллээ. Нийт хариулагчдын 37.1 хувь нь намуудын дотоод эв нэгдэл, сахилга бат, 30.4 хувь нь дотоод ардчилал чухал гэсэн бол 18.8 хувь нь төр барих, 13.7 хувь нь зөвшилд хүрэх шинж чанар чухал гэсэн байна.

Аймаг/хотоор ялгаатай авч үзвэл, намуудын дотоод ардчилал чухал гэж Улаанбаатар хотын хариулагчид бусад аймгийнхнаас өндөр хувьтай (38.0 хувь) байсан бол намуудын дотоод эв нэгдэл, сахилга бат чухал гэж Увс, Хөвсгөл аймгийн хариулагчид (39.0 хувь, 45.5 хувь) бусад аймгийн хариулагчдаас илүү үзжээ.

Хүснэгт 3.4: Улс төрийн намд байх ёстой шинжүүдийн талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Төр барих	13.5	20.5	12.5	22.5	23.0	18.8
Зөвшилд хүрэх	22.0	18.5	19.5	6.0	6.3	13.7
Дотоод эв нэгдэл\сахилга бат	36.5	34.0	39.0	45.5	32.7	37.1
Дотоод ардчилал	28.0	27.0	29.0	26.0	38.0	30.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Парламентийн сонгуульд дэмжихийг хүсдэг боловч тухайн нам нь сонгуульд суудал авахгүй нь илэрхий учраас өөр намд саналаа өгч байсан эсэх талаар

хариулагчдын дийлэнх олонх буюу 85.3 хувь нь тийм тохиолдол байгаагүй гэсэн бол үлдсэн 14.7 хувь нь тийм тохиолдол байсан буюу дэмжиж байгаа нам нь сонгуульд суудал авахгүй нь илэрхий учраас өөр намд саналаа өгч байсан гэжээ. Аймгуудтай харьцуулахад ийм тохиолдол Улаанбаатар хотын хариулагчдын хувьд арай өндөр (20 хувь) байна.

Хүснэгт 3.5: Дэмжихийг хүсдэг боловч тухайн нам сонгуульд суудал авахгүй нь илэрхий учраас өөр намд саналаа өгч байсан эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Саналаа өгч байсан	15.5	14.5	11.5	9.5	20.0	14.7
Саналаа өгч байгаагүй	84.5	85.5	88.5	90.5	80.0	85.3
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Ийнхүү сонгогчдын тодорхой хэсэг нь өөрсдийнхөө дэмждэг, ашиг сонирхлыг нь төлөөлж чадна гэсэн улс төрийн хүчний төлөө саналаа өгч чадахгүй байгаа нь хүмүүсийн улс төрийн идэвх буурах нэг шалтгаан байж болох юм. Нийт сонгогчдын сонгуульд оролцож буй идэвх сүүлийн хоёр сонгуулиар буурч байгаа нь үүний нэг жишээ. Ийнхүү парламентийн сонгуульд томоохон цөөн хэдэн намуудын төлөөлөл давамгайлах, жижиг намуудын төлөөлөл гарч ирж чадахгүй байх нөхцөл бүрдээд байна гэж хэлж болохоор байна. Өөрөөр хэлбэл, сонгогчид өөрийн хүссэн/дэмжсэн намын төлөө саналаа өгдөг тогтолцоо бус (дэмждэг нам нь сонгуульд гарч ирэхгүй нь тодорхой учир) дэмждэггүй намынхаа эсрэг талын хүнийг сонгуульд гаргахын төлөө саналаа өгдөг тогтолцоотой байна гэсэн үг.

2004 оны сонгуулиар парламентад улс төрийн хоёр том хүчин болох МАХН, Ардчилсан Эвсэл тэнцүү төлөөллөөр гарч ирсэн билээ. Энэ хоёр хүчин өнөөгийн нийгмийн бүх ашиг сонирхлыг илэрхийлж чадаж байгаа эсэх талаар нийт хариулагчдын санал ерөнхийдөө тэнцүү хуваагдсан буюу 34.1 хувь нь нийгмийн бүх ашиг сонирхлыг илэрхийлж чадахгүй байна, 33.3 хувь нь чадаж байна гэсэн бол үлдсэн 32.6 хувь нь энэ талаар хэлж мэдэхгүй байна гэсэн байна.

Хүснэгт 3.6: Улс төрийн хоёр том хүчин өнөөгийн нийгмийн бүх ашиг сонирхлыг илэрхийлж чадаж байгаа эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Илэрхийлж чадаж б\а	31.5	45.0	35.0	20.5	34.0	33.3
Илэрхийлж чадахгүй б\а	34.5	25.5	29.5	32.5	43.7	34.1
Намууд хоорондоо зөрчилтэй учраас	27.5	17.5	15.5	23.5	25.0	22.1
Намууд өөрсдийн эрх ашгийн төлөө ажилладаг учраас	0.5	2.0	9.5	6.5	4.3	4.6
Жижиг намуудын төлөөлөл байхгүй учраас	4.0	5.5	2.0	0.5	12.7	5.6
Бусад	2.5	0.5	2.5	2.0	1.7	1.8
Мэдэхгүй	34.0	29.5	35.5	47.0	22.3	32.6
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Энэ хоёр улс төрийн хүчин нийгмийн ашиг сонирхлыг илэрхийлж чадахгүй байна гэсэн хувь Улаанбаатарт бусад аймгаас өндөр (43.7 хувь) байлаа. Намууд хоорондоо зөрчилтэй учраас нийгмийн ашиг сонирхлыг илэрхийлж чадахгүй байна гэсэн хувь аль ч аймаг/хотод адил бусад хариултаас өндөр хувьтай байна. Жижиг намуудын төлөөлөл байхгүй байгаа нь нийгмийн ашиг сонирхлыг илэрхийлж чадахгүй байна гэж Улаанбаатар хотын хариулагчид бусад аймгаас илүүтэйгээр хариулжээ.

Ийнхүү улс төрийн хоёр том хүчин засгийн газраа хамтран байгуулж байгаа нь нэг талаас УИХ-д сөрөг хүчин байхгүй болгож байгаа хэрэг бөгөөд бусад намуудын сонирхол төлөөлөгдөхгүй хоцрох нөгөө талаас, хоёр хэсэгт хуваагдсанаар зөвхөн улс төрийн хүрээнд бус нийгмийн хувьд ялгаварлалыг бий болгож байна.

Хариулагчдын дөнгөж гуравны нэг орчим нь л улс төрийн хоёр том хүчин өнөөгийн нийгмийн бүх ашиг сонирхлыг илэрхийлж чадаж байна гэж хариулсныг дээр дурьдсан. Тэгвэл хариулагчдын талаас илүү хувь нь (54.9 хувь) парламентад нэг нам үнэмлэхүй олонхийн суудал авч засгийн газраа байгуулах нь зүйтэй

тэгэхдээ парламент олонхтойгоо харьцангуй тэнцвэртэй, сөрөг хүчинтэй байх нь зүйтэй (64.8 хувь) гэжээ.

Хүснэгт 3.7: Парламентад нэг нам үнэмлэхүй олонхийн суудал авч засгийн газраа байгуулах нь зүйтэй эсэх талаар болон парламент олонхтойгоо харьцангуй тэнцвэртэй, хүчтэй сөрөг хүчинтэй байх нь зүйтэй эсэх талаарх хариулагчдын хувийн жин

	Парламентад нэг нам үнэмлэхүй олонхийн суудал авч засгийн газраа байгуулах нь зүйтэй эсэх талаар	Парламент олонхтойгоо харьцангуй тэнцвэртэй, хүчтэй сөрөг хүчинтэй байх нь зүйтэй эсэх талаар
Зүйтэй гэж бодож байна	54.9	64.8
Буруу гэж үзэж байна	45.1	20.2
Мэдэхгүй	0.0	15.0
Бүгд	100.0	100.0
Тоо	1100	1100

Ийнхүү парламентад нэг нам давамгайлах бус харин түүнийг хянах, олон янзын үзэл бодлыг илэрхийлэх сөрөг хүчний дуу хоолойг сонгогчид хүсэж байна. Ингэхийн тулд нөлөө бүхий сөрөг хүчний төлөөлөл УИХ-д “орших” зохицуулалтыг өнөөгийн сонгуулийн системд бий болгох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

3.3 Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаа

Судалгааны энэ хэсэгтээ олон нийт Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны талаар ямар бодол, сэтгэгдэлтэй явдаг болон тэдний үйл ажиллагааны талаар хэр зэрэг эерэг, сөрөг ойлголттой байдаг тухай авч үзсэн юм.

Юуны түрүүнд Сонгуулийн ерөнхий хороо аль нэг намын хараат бус байдлаар дангаараа бие даан ажиллаж чадаж байгаа эсэхийг тодруулахад судалгаанд оролцогчдын тал хувь бие даан ажиллаж чадахгүй байгаа гэж боддог ажээ. Нийт оролцогчдын таван хүн тутмын нэг нь Сонгуулийн ерөнхий хороо бие даан ажиллаж чадаж байгаа гэж хариулсан байхад бараг 25 орчим хувь нь бие даан ажиллаж чаддаг эсэхийг нь хэлж мэдэхгүй гэжээ.

Хүснэгт 3.8: Сонгуулийн ерөнхий хороо бие даан ажиллаж чадаж байгаа эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Чадаж байна	26.5	37.0	22.5	13.0	21.7	23.9
Чадахгүй байна	44.5	30.0	51.5	57.0	65.7	51.2
Эрх баригч намын дарамт шахалт	15.5	7.0	14.0	15.5	18.7	14.5
Нэр дэвшигчдээс хахууль авдаг	3.5	9.0	9.0	14.5	10.0	9.3
Албан тушаалын барьцаанд байдаг	22.0	7.0	28.5	26.5	34.0	24.6
учраас						
Бусад	3.5	7.0	0.0	0.5	3.0	2.8
Мэдэхгүй	29.0	33.0	26.0	30.0	12.7	24.9
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Аймаг, хотын ялгаатай байдлаар харвал, Улаанбаатар хотын судалгаанд хамрагдсан хүмүүсийн бараг гуравны хоёр орчим нь Сонгуулийн ерөнхий хороо бие даан ажиллаж чаддаггүй гэж үзэж байхад Өмнөговьчуудын хувьд ийм хариулт бусад аймгуудтай харьцуулахад бага байна.

Сонгуулийн ерөнхий хороо бие даан ажиллаж чадахгүй байгаа гэсэн бодолтой хүмүүсээс яагаад ингэж үзэж байгааг тодруулахад, тэд албан тушаалын барьцаанд байдаг, эрх баригч намын дарамт, шахалтад ордог учраас бие дааж ажиллах бололцоогүй гэж үзэж байна. Мөн нэр дэвшигчдээс хээл хахууль авдаг гэсэн хариултыг бараг 10 орчим хувь нь өгсөн байна. Ярилцлага авч байх явцад Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааг шүүмжлэх, тэдний ажлын эцсийн үр дүн болон явуулж буй үйл ажиллагаа зэрэгт сэтгэл ханамжтай бус байгаагаа судалгаанд оролцогчид ярьж байсан.

Мөн бие даасан үйл ажиллагааны талаарх ойлголтыг баталгаажуулах үүднээс сонгуулийн тойрог, хэсгийн хороодын зохион байгуулалтын асуудалд эрх баригч

хүчнээс ямар нэг нөлөө үзүүлж, өөрийн сонирхлын дагуу зохион байгуулалтыг хийдэг явдал байдаг эсэх талаарх олон нийтийн бодлыг тандахад судалгаанд хамрагдагсдын гуравны хоёр нь эрх баригч хүчний сонирхол сонгуулийн тойрог, хэсгийн хороодыг зохион байгуулахад давамгайлдаг гэж бодож байна.

Хүснэгт 3.9: Сонгуулийн тойрог, хэсгийн хороодыг зохион байгуулахад эрх баригч хүчний сонирхол давамгайлдаг эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Эрх баригч хүчний сонирхол давамгайлдаг	57.0	58.0	59.5	67.0	66.3	62.0
Эрх баригч хүчний сонирхол давамгайлдаггүй	43.0	42.0	40.5	33.0	33.7	38.0
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Нийт судалгаанд оролцогчдын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд хээл хахуульд өртсөн эсэх талаар бодлыг тандахад, тэдний гуравны нэг орчим нь хээл хахуульд өртсөн, 24.3 хувь нь хээл хахуульд өртөөгүй, үлдсэн 45.1 хувь нь энэ талаар сайн мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.

Хүснэгт 3.10: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд хээл хахуульд өртсөн эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Хээл хахуульд өртсөн	21.0	28.0	28.0	32.5	39.3	30.6
Хээл хахуульд өртөөгүй	24.0	28.0	26.5	17.5	25.0	24.3
Мэдэхгүй	55.0	44.0	45.5	50.0	35.7	45.1
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Тэд хээл хахууль, авилгалтай холбоотой асуудлаар нэлээд шүүмжлэлтэй хандаж, хэрэв ямарваа нэгэн хууль эрхийн актад харшлахгүй бол Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийн орлого, зарлагын мэдүүлгийг олон нийтэд мэдээлж байх нь

зүйтэй гэсэн саналыг хэлж байсан. Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийн орлого, зарлагын мэдүүлгийг олон нийт мэдэх нь зүйтэй гэж үзэж байхад 23.7 хувь нь энэ бол хувь хүний асуудал тул олон нийт заавал энэ мэдээллийг авах албагүй гэсэн байр суурьтай байна. Харин тэдний тавны нэг хувь нь энэ талаар ерөөсөө бодож байгаагүй тул ямар нэгэн хариулт өгч чадахгүй гэсэн байна.

Хүснэгт 3.11: Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийн орлого, зарлагын мэдүүлгийг олон мэдэж байх хэрэгтэй эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Тийм, мэдэж байх хэрэгтэй	50.5	65.5	50.5	56.5	59.7	55.9
Үгүй, энэ бол хувь хүний асуудал	25.5	16.5	22.5	29.0	28.0	23.7
Хэлж мэдэхгүй байна	24.0	18.0	27.0	14.5	12.3	20.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Дээрх байдлаас дүгнэж хэлэхэд, Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаанд олон нийт төдийлэн сэтгэл хангалуун байж чаддаггүй бөгөөд тэдний үйл ажиллагаанд эрх баригч хүчний дарамт, шахалт, үр нөлөө их байдаг гэж үзэж байна. Мөн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд ямар нэг хэмжээгээр авилгал, хээл хахуульд өртдөг. Иймд тэдний орлого, зарлагын мэдүүлгийг олон нийтэд нээлттэй ил тод байлгах нь зөв гэж үзэж байна.

3.4 Сонгуулийн санхүүжилт

Аль ч улс оронд сонгуулийн санхүүжилт болон хөрөнгө оруулагчид ард олон нийтийн сонирхлыг татаж байдаг. Мөнгө бол улс төрийн хүчил төрөгч гэж ярьдгийг бид мэдэх билээ. Тиймээс энэ судалгаагаар олон нийт сонгуулийн санхүүжилтийн талаар ямар үзэл бодолтой байгааг сонирхсон юм.

Нам болон нэр дэвшигчид сонгуулийн үеэр олсон болон зарцуулсан хөрөнгийн хэмжээг олон нийтэд нээлттэй зарлах нь зөв эсэх талаар асуултад судалгаанд хамрагдсан хүмүүс хэрхэн хариулт өгсөнийг Хүснэгт 3.12-д харуулав.

Хүснэгт 3.12: Нам ба нэр дэвшигчдийн сонгуулийн үеэр олсон болон зарцуулсан хөрөнгийн хэмжээг олон нийтэд нээлттэй зарлах нь зөв эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Олон нийтэд ил тод зарлах нь зөв	47.5	57.0	52.0	43.5	59.7	52.6
Зарим мэдээллийг зарлах нь зөв	27.0	25.0	32.0	23.5	22.0	25.6
Олон нийт заавал мэдэх албагүй	25.5	18.0	16.0	33.0	18.3	21.8
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Судалгаанд хамрагдсан нийт хүн амын дийлэнх буюу 52.6 хувь нам, нэр дэвшигчдийн сонгуулийн үеэр олсон болон зарцуулсан хөрөнгийг олон нийтэд ил тод зарлах нь зөв гэсэн хариултыг өгчээ. Харин олон нийтэд заавал мэдээлэх албагүй гэж хариулагчдын 21.8 хувь, мөн 25.6 хувь нь зөвхөн зарим мэдээллийг зарлах нь зөв гэж хариулсан байна.

Дээрх асуултад хариулсан байдлыг аймаг, хотоор авч үзэхэд онцын ялгаа ажиглагдахгүй, ижил хандлагатай байгаа боловч олон нийтэд ил тод зарлах нь зөв гэж хариулсан хариулагчдын хувь Улаанбаатарт хамгийн өндөр (59.7 хувь), харин Хөвсгөлд хамгийн бага буюу 43.5 хувь байв. Түүнчлэн олон нийт заавал мэдэх албагүй гэсэн хариултыг Хөвсгөл аймгаас судалгаанд хамрагдсан хүмүүсийн 33 хувь хариулсан нь бусад аймаг, хоттой харьцуулахад хамгийн өндөр байгаа юм. Харин зөвхөн зарим мэдээллийг зарлах нь зөв гэж үзэж байгаа хүмүүсийн хувь Увс аймагт 32.0 байгаа нь нийт түүврийн энэ үзүүлэлтээс 6.4 пунктээр өндөр байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсээс өнгөрсөн 2004 оны сонгуульд зарцуулсан төсөв хөрөнгө ил нээлттэй байж чадсан эсэх талаар сонирхоход дараах дүр зураг ажиглагдлаа.

Хүснэгт 3.13: 2004 оны сонгуульд зарцуулсан төсөв хөрөнгө ил, нээлттэй байж чадсан эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Ил, нээлттэй байсан	7.0	13.5	3.0	3.0	8.3	7.1
Нээлттэй байж чадаагүй	46.0	54.5	54.0	53.5	61.3	54.5
Энэ тухай сонирхоогүй	36.0	14.5	30.0	30.0	25.4	27.0
Мэдэхгүй	11.0	17.5	13.0	13.5	5.0	11.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Судалгаанд оролцогчдын дийлэнх (54.5 хувь) өнгөрсөн 2004 оны сонгуульд зарцуулсан төсөв хөрөнгө ил, нээлттэй байж чадаагүй гэж үзсэн бөгөөд нээлттэй байж чадсан гэсэн хариулт өгсөн хүмүүсийн хувь хамгийн бага 7.1 хувь байна. Мөн судалгаанд хамрагдагсдын багагүй хэсэг (27.0 хувь) нь энэ тухай сонирхоогүй гэж хариулжээ.

Аймаг, хотын хувьд ялгаа ямар байгааг үзэхэд, Өмнөговь аймагт дээрх асуултанд хариулсан байдал бусад аймаг, хоттой харьцуулахад нэлээд өөр байгаа нь ажиглагдаж байна. Өнгөрсөн сонгуулийг ил, нээлттэй байсан гэж үзэж буй хүмүүсийн хувь Өмнөговьд бусад аймаг, хоттой харьцуулахад хамгийн өндөр буюу 13.5 хувь байгаа юм. Мөн энэ талаар сонирхож байгаагүй хүмүүсийн хувь хамгийн бага (14.5 хувь), харин мэдэхгүй гэсэн хариулт өгсөн хүмүүс бусад аймаг, хоттой харьцуулахад харьцангуй өндөр (17.5 хувь) байв.

Судалгаанд хамрагдсан бусад аймаг болон Улаанбаатар хотын хариулагчдын хариулт өгсөн байдал нийт судалгаанд хамрагдсан хүн амын ерөнхий хандлагатай ижил байна. Гэхдээ сонгуульд зарцуулсан төсөв хөрөнгө нээлттэй байж чадаагүй

гэж үзэж буй хүмүүсийн хувь Улаанбаатарт хамгийн өндөр буюу 61.3 хувь байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Монголын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр сонгуульд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн хүмүүс ямар нэгэн албан тушаалд очиж байгаа талаар нийтэлж энэ асуудалд нэлээд шүүмжлэлтэй ханддагийг бид мэдэх билээ. Олон нийт энэ талаар ямар үзэл бодолтой байгааг энэ судалгаанд асуусан бөгөөд үр дүнг Хүснэгт 3.14-т харууллаа.

Хүснэгт 3.14: Сонгуулийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн хүмүүс дараа нь ямар нэгэн албан тушаалд очих нь зөв эсэх талаарх хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Хөвсгөл	Улаанбаатар	
Зөв	11.0	16.5	16.0	10.0	13.7	13.5
Буруу	52.0	64.0	51.5	56.0	70.3	59.8
Сайн хэлж мэдэхгүй байна	37.0	19.5	32.5	34.0	16.0	26.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 60 орчим хувь сонгуульд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн хүмүүс албан тушаалд очих нь “буруу” гэж хариулжээ. “Зөв” гэсэн хариулт өгсөн хүмүүсийн хувь хамгийн бага 13.5 хувь, үлдсэн 26.7 хувь сайн хэлж мэдэхгүй гэсэн байна. “Сайн хэлж мэдэхгүй байна” болон “зөв” гэсэн хариулт өгсөн хүмүүс хариултандаа тайлбар өгөхдөө мэдлэг, чадвараараа тэнцэж байвал албан тушаалд очихыг үгүйсгэж болохгүй, харин санхүүгийн дэмжлэг үзүүлсэн эсэх нь шалгуур болж байгаа бол зарчмын хувьд буруу гэсэн бодолтой байсныг энд дурьдах нь зүйтэй. Мөн албан тушаалд томилоход чухам ямар журам үйлчилдэг талаар хүмүүс ойлголт багатай байдаг учраас энэ асуултанд хариулахад хүндрэл учирч байсан нь ажиглагдаж байлаа.

Дээрх хандлага судалгаанд хамрагдсан бүх аймаг, хотын хувьд ижил байгаа юм. Гэхдээ Улаанбаатар хот (70.3 хувь) болон Өмнөговь аймагт (64.0 хувь) сонгуулийн

үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн хүмүүс ямар нэгэн албан тушаалд очих нь буруу гэсэн бодолтой хүмүүсийн хувь хамгийн өндөр, байв.

Дүгнэж хэлэхэд, олон нийт сонгуулийн үеэр нам, нэр дэвшигчдийн олсон болон зарцуулсан хөрөнгийн хэмжээг мэдэх сонирхолтой байдаг бөгөөд өнгөрсөн 2004 оны сонгуулийн төсөв хөрөнгө ил нээлттэй байж чадаагүй гэж үзэж байна. Иймд, намууд сонгуулийн төсөв, ялангуяа төсвийн зарцуулалтыг ил тод, нийтэд хүртээмжтэй хэлбэрээр зарлахад анхаарч ажиллах шаардлага харагдаж байгаа юм. Түүнчлэн, сонгуулийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн хүмүүс дараа нь ямар нэгэн албан тушаалд очдогийг судалгаанд хамрагдсан хүмүүсийн дийлэнх буруу гэж үзэж байгаа нь намууд, улс төрчид энэ асуудалд цаашид анхаарлаа хандуулах нь зүйтэй.


3.5 Их эвслийн засгийн газрын талаарх үзэл бодол

Ардчилсан улс орнуудад Засгийн газрын үйл ажиллагаанд олон нийт бүрэн хангалуун байна гэж байдаггүй. Ялангуяа, эдийн засаг, нийгмийн олон асуудлуудтай тулгарч байдаг хөгжиж буй нийгэмд, тэр тусмаа манайх шиг улс төрийн хоёр хүчин Их хуралд тэнцүүхэн суудал авч гарч ирсэн улсад энэ нь зайлшгүй илрэх үзэгдэл гэж хэлж болох юм. Тэгвэл олон нийт Их эвслийн засгийн газрын үйл ажиллагааны талаар ямар үзэл бодолтой байгааг энэ хэсэгт товч авч үзье.

Их эвслийн засгийн газрын мөрийн хөтөлбөрт намуудын амлалт бүрэн ороогүй талаар олон нийтийн үзэл бодлыг Зураг 3.4-д харуулав.

Судалгаанд хамрагдсан нийт хариулагчдын дийлэнх буюу 43.1 хувь сонгуульд ялахын тулд амалсан амлалт тул засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулаагүй гэсэн хариулт өгжээ. Мөн таван хүн тутмын нэг нь амалсан л бол биелүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Зураг 3.4: Их эвслийн засгийн газрын мөрийн хөтөлбөрт намуудын амлалт бүрэн ороогүй талаарх санал



Энэ үзүүлэлт хот, аймгуудын хувьд нэлээд ялгаатай байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал, Улаанбаатар хот болон Өмнөговь аймагт судалгаанд хамрагдсан хүмүүсийн талаас илүү нь (63.0 хувь ба 51.0 хувь) сонгуульд ялахын тулд амалсан учраас хөтөлбөрт оруулаагүй гэсэн хариултыг өгсөн байхад Увс, Хөвсгөлөөс судалгаанд хамрагдагсдын тус тус 24.5, 23.0 хувь дээрх байдлаар хариулсан байгаа юм. Мөн амалсан л бол биелүүлэх шаардлагатай гэж үзэж буй хүмүүсийн хувь Өмнөговь, Дорнод аймагт харьцангуй өндөр, нийт судалгаанд хамрагдагчдын хувьд тооцсон үзүүлэлтээс (20.1 хувь) тус тус 11.4, 8.4 пунктээр өндөр байгаа дүн гарчээ.

Түүнчлэн дээрх асуултанд “мэдэхгүй” гэж хариулсан хүмүүсийн хувь 21.8 хувь байгаа нь сонирхолтой. Аймгуудын хувьд авч үзэхэд, дээрх хариултыг өгсөн хүмүүсийн хувь Увс (40.5 хувь), Хөвсгөл (33.5 хувь) аймгуудад хамгийн өндөр байв. Энэ нь олон нийтийн улс төр, нийгмийн идэвхийг илэрхийлэх үзүүлэлт болж болох бөгөөд иргэдийн нийгмийн идэвх хэр зэрэг сул байгааг харуулж байгаа хэрэг юм.

Дээрх хариултуудаас гадна эвсэж засгийн газар байгуулсан тул амлалтуудыг бүгдийг нь оруулах боломжгүй (судалгаанд хамрагдсан хүн амын 7.6 хувь), улсын төсөв, чадавх муу тул амлалтууд хэрэгжих боломжгүй (6.9 хувь) гэсэн хариултуудыг өгсөн байлаа.

Судалгаанд хамрагдсан хүн амаас Их эвслийн засгийн газрыг хийгээсэй гэж хүсэж буй зүйлүүдийн талаар асуухад нэлээд олон зүйлийг хэлж байв. Үр дүнг Хүснэгт 3.15-т харууллаа.

Нийт хариулагчдын дийлэнх болох 62.7 хувь нь амалсан амлалтаа биелүүлээсэй гэсэн хариулт өгсөн байна. Энэ хандлага судалгаанд хамрагдсан бүх аймаг, нийслэл хотын хувьд ч ижил байгаа юм. Олон нийт сонгуульд санал өгөхдөө намуудын мөрийн хөтөлбөрийг нэлээд анхааралтай үздэг нь мэдээж. Тийм ч учраас намууд аливаа амлалтыг мөрийн хөтөлбөртөө оруулахдаа эдийн засаг, санхүүгийн үндэслэлийг нарийн тооцсон, холбогдох мэргэжилтнүүдийн шинжилгээ, судалгаанд суурилсан байдаг гэдэгт ард иргэд итгэдэг учраас намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт амалсан амлалт заавал бүрэн хэрэгжих ёстой гэж үзэн, амлалтаа биелүүлэхийг чин сэтгэлээсээ хүсэж байгаа ажээ.

Дээрх хариултаас гадна ядуурлыг бууруулах (4.6 хувь), цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх (4.6 хувь), ажилгүйдлийг бууруулах, ажлын байр бий болгох (2.7 хувь), дэд бүтцийг хөгжүүлэх (2.4 хувь) гэсэн хариултууд нийт түүврийн дунд тодорхой хувийг эзэлж байна.

Хүснэгт 3.15: Их эвслийн засгийн газрыг хийгээсэй гэж хүсэж буй зүйлүүд, хариулагчдын хувийн жин, аймгаар

	Аймаг\Хот					Бүгд
	Дорнод	Өмнөговь	Увс	Ховсгөл	Улаанбаатар	
Нийгмийн талаар						
Ажилгүйдлийг бууруулах\ажлын байр бий болгох	3.5	1.5	1.0	4.5	3.0	2.7
Ядуурлыг бууруулах	4.5	5.5	2.5	7.0	4.0	4.6
Нийгмийн бүлгүүдийг анхаарах, дэмжих	1.0	1.0	0.5	0.5	1.3	0.9
“Орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлэх	2.5	1.0	1.0	0.0	1.7	1.3
Боловсрол\эрүүл мэндийн салбарын хөгжлийг сайжруулах	1.5	4.0	1.5	1.5	1.3	1.9
Эдийн засгийн талаар						
Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх	4.0	6.0	10.0	0.0	3.7	4.6
Татвар\зээлийн хүүг багасгах\жижиг зээлийг дэмжих	2.0	2.5	0.5	3.0	1.3	1.8
Хувийн хэвшил\үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих	0.0	0.5	1.5	1.5	1.7	1.1
Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн талаар						
Дэд бүтцийг хөгжүүлэх	5.5	2.5	1.5	1.0	1.7	2.4
Хот, хөдөөгийн ялгааг Арилгах	0.5	1.0	0.5	1.0	0.7	0.7
Төрийн удирдлага, хууль эрхийн талаар						
Хээл хахуулийг устгах\Хүнд суртлыг арилгах	0.0	1.0	0.0	1.0	1.3	0.7
Зөвшилцөж сурах\хамтарч ажиллах	0.0	0.5	3.0	2.5	0.7	1.3
Хөгжлийн хүн рүү чиглэсэн бодлого хэрэгжүүлэх	0.0	1.0	6.5	0.5	0.3	1.5
Хуулиудыг эргэн харах\хэрэгжилтийг хянах	0.5	0.0	1.0	1.5	0.0	0.5
Бусад	1.5	2.0	3.5	3.5	4.7	3.2
Амалсан амлалтаа биелүүлэх	65.0	69.5	47.5	56.5	71.0	62.7
Мэдэхгүй	8.0	0.5	18.0	14.5	1.7	7.9
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тоо	200	200	200	200	300	1100

Эцэст нь хэлэхэд, судалгаанд оролцогчид намуудыг гагцхүү сонгуульд ялахын тулд худлаа амлалт өгсөн гэж үнэлж дүгнэж байна. Иймэрхүү нөхцөл байдлаас болж намуудад итгэх олон нийтийн итгэл цаашид суларч болзошгүйг анхаарч, амалсан л бол амлалтаа биелүүлэхийн төлөө Их эвслийн засгийн газар ажиллах нь зүйтэй юм.

БҮЛЭГ 4. САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол улсын сонгуулийн системийн талаарх олон нийтийн үзэл бодлыг тандах судалгааны үр дүнг үндэслэн дараах санал, дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Өнөөгийн сонгуулийн системийн талаарх мэдлэг муу, сонгуулийн хууль, сонгуулийн ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг хангалтгүй байна. Иймд ард иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, иргэдийн оролцоо идэвхийг сайжруулах үүднээс сонгуулийн хууль, сонгуулийн систем, УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын үйл ажиллагааг таниулан сурталчлах ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах хэрэгтэй.
- Судалгаанд оролцогчдын дийлэнх нь одоогийн сонгуулийн систем “буруу” гэж үзэж байна. Учир нь сонгогчдын санал болон сонгуулийн дүн, парламент дах төлөөлөл хоорондын холбоонд олон нийт сэтгэл хангалуун бус, өнөөгийн сонгуулийн систем бодит байдалтай нийцэхгүй байгаа гэж онцлон тэмдэглэж байна. Иймд сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж, сонгуулийн системийг өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна.
- Сонгогчид болон нам, эвсэл, улс төрийн хүчнийхэн сонгуульд нэр дэвшигчийг гаргаж ирэхдээ тухайн нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг (боловсрол, чадвар, ажлын туршлага, улс төрийн соёл гэх мэт) илүү эрхэмлэдэг байдал нийтлэг байгаа ч зарим тохиолдолд зөвхөн бэл бэнчин харж дэвшүүлэн, улмаар тухайн мөнгө, хандив өргөгчдийг сонгуулийн дараагаар албан тушаалд томилох явдал байгааг олон нийт буруушааж байна.
- Сонгогчид өөрсдийн дэмждэг, ашиг сонирхлыг нь хамгаалж чадна гэж үздэг улс төрийн намынхаа төлөө саналаа өгч чадахгүй байна. Сонгогчид уг нь тухайн намын төлөө саналаа өгөхийг хүсдэг ч, нэгэнт тухайн нам дэмжлэг авахгүй нь

илэрхий болсноос болж өөр нам, эвслийн төлөө саналаа өгөхөд хүрч байна. Энэ бол одоогийн сонгуулийн системийн үр дагавар гэдэг нь илэрхий билээ. Иймд сонгогчдын сонгох эрхийг хүндэтгэх үүднээс сонгуулийн системийг эргэн харах хэрэгтэй байгааг анхаарах нь зүйтэй юм.

- Сонгогчдын үзэж байгаагаар УИХ-д сөрөг хүчний дуу хоолой үгүйлэгдэж байна. Сонгогчид улс төрийн хоёр том хүчин гарч ирэн засгийн газраа байгуулан ажиллаж байгаа ч тэдгээр нь олон нийт, нийгмийн эрх ашиг, сонирхлыг төдийлэн илэрхийлж чадахгүй байна гэж үзэхийн зэрэгцээ жижиг намуудын төлөөлөл болон олонхтойгоо тэнцвэртэй, хүчтэй сөрөг хүчин зайлшгүй байх хэрэгтэй гэж үзэж байна.
- Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаа олон нийтийн хүсэл сонирхолд нийцэхгүй байна. Сонгогчид Сонгуулийн ерөнхий хороо бие даан ажиллаж чаддаггүй, эрх баригч хүчний дарамт шахалтын дор үйл ажиллагаа явуулдаг, мөн авилгал хээл хахуульд өртөгдсөн гишүүдтэй гэж үзэж байна. Мөн тэд Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааны талаар тодорхой мэдээ мэдээлэлтэй байж чадахгүй байна. Иймд Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагааг олон нийтэд таниулах, хорооны үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангахыг хүсч байна.
- Аливаа сонгуулийн санхүүжилт буюу нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн үеэр олсон болон зарцуулсан хөрөнгийн хэмжээг олон нийт мэдэж байх нь зүйтэй гэж үзэн, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ил тод, нээлттэй зарлах нь сонгуулийн элдэв будлиан, маргаанаас ангижрах нэг арга гэж үзэж байна.
- Их эвслийн засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт сонгуулийн амлалтууд бүрэн тусгагдаагүйд ард иргэд таатай бус байна. Амалсан л бол амлалтаа биелүүлэхийн төлөө бүх нөөц бололцоогоо дайчлах хэрэгтэй. Хэрэв сонгуульд ялахын тулд амлалт авч байгаа бол буруу зүйл гэж үзэн цаашид ингэж ард иргэдээ хууран мэхлэхгүй, тэдний итгэлийг алдахгүй байхын төлөө ажиллаасай гэж хүсч байна.